**“ДАРАА ҮЕИЙН ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ СИСТЕМД АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТАЛААР ТАНИЛЦУУЛГА**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Радио долгионы тухай хуулийн $5^1$ дүгээр зүйлийн $5^1$.1.2-д заасан чиг үүргийн дагуу “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлан гаргаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 6452 дугаарт бүртгүүлсэн.

Уг баримт бичиг нь 5 бүлэг, 27 заалт, 12 хэсэг, 10 хавсралттай.

Тус хорооноос Мобиком корпораци ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК, Жи мобайл ХХК, Ондо ХХК-уудад дээрх баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхэд санал авахаар 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 05/228 тоот албан бичгийг хүргүүлсэн. Энэхүү албан бичгийн хариуг Мобиком корпораци ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК, Жи мобайл ХХК болон Мэдээлэл холбооны операторуудын ассоциациас тус тус ирүүлсэн болно.

Нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөл, шаардлагын төсөлд Скайтел ХХК-аас дөрөв, Юнител ХХК-аас долоо, Мобиком корпораци ХХК-аас арван нэг, Жи мобайл ХХК-аас дөрөв, Мэдээлэл холбооны операторуудын ассоциациас арван нэг нийт 37 санал ирүүллээ.

Ирүүлсэн саналын хүрээнд тус хорооноос 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, “Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци” ГҮТББ болон үүрэн холбооны оператор компаниудын дунд уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм.

Дээрх саналууд болон хэлэлцүүлгээс гарсан саналуудаас нөхцөл, шаардлагын заалтыг хэт дэлгэрүүлсэн, хуульд тусгагдсан үг хэллэгийг тайлбарлан нэр томъёоны тодорхойлолт болгосон зэрэг ач холбогдолгүй 4 саналыг тусгахаас татгалзаж, бусад 33 саналыг нөхцөл, шаардлагад нэмэлт өөрчлөлтөөр тусган боловсруулж, 5 бүлэг, 28 заалт, 11 хэсэг, 10 хавсралт гэсэн бүтэцтэй болоод байна.

Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан тогтоолын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу тус хорооны www.crc.gov.mn цахим хуудсанд 2026 оны 07-р сарын 08-ны өдрөөс 2026 оны 08-р сарын 18-ны өдөр хүртэл 40 хоногийн хугацаанд санал авахаар нийтийн хэлэлцүүлэгт байршуулж байна.

Энэхүү “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын нэмэлт, өөрчлөлт нь радио давтамжийн эрэлт, хэрэгцээг хангаж, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлтийг оруулах төсөл

<table>
<tr><th>Заалтын дугаар</th><th>Төсөл</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td>1.1</td><td>Энэхүү баримт бичиг нь Дэлхийн радио холбооны дүрэм, Радио долгионы тухай хууль, Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт (цаашид ҮРДХХ гэх) болон Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл (цаашид бодлогын чиглэл гэх)-ийг тус тус үндэслэн дараа үеийн хөдөлгөөнт холбооны (цаашид ДҮХХ гэх) системд ашиглах радио давтамж (РД)-ийн зурвасын хуваарилалт, баримтлах зохицуулалт, техникийн нөхцөл шаардлагыг тодорхойлно.</td><td rowspan="3">Өөрчлөн найруулах</td></tr>
<tr><td>2.2</td><td>Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт (ЦХХХЯ-ны сайдын 2025 оны А/46 дугаар тушаал)</td></tr>
<tr><td>3.6</td><td>Үйлчилгээ эрхлэгч нь үндэсний эсхүл олон улсын хөдөлгөөнт холбооны стандартчиллын байгууллагын 3GPP-ын холбогдох стандартыг баримтална.</td></tr>
<tr><td>4.1.2</td><td>ОУЦХБ-аас ДҮХХ-ны системд батлагдсан РД-ийн зурвасаас олон улсад илүү өргөн ашиглаж буй РД-ийн зурвасыг өөрийн орны онцлогт тохируулан хуваарилах.</td><td>Хүчингүй болгох</td></tr>
<tr><td>4.2-ын хүснэгт 1</td><td>ДҮХХ-ны системд ашиглах РД-ийн зурвасууд хүснэгтэд:<br><table><tr><td>11</td><td>6425-7125</td></tr></table></td><td>Хэсгийг нэмэх</td></tr>
<tr><td>4.3</td><td>ДҮХХ-ны системд ашиглах РД-ийн зурвасын хуваарилалтыг хийхдээ Олон Улсын хөдөлгөөнт холбооны стандартчиллын 3GPP[9] байгууллагаас баталсан РД-ийн зурвасын хуваарилалтыг мөрдөнө (Хүснэгт 2).</td><td>Хүчингүй болгох (хүснэгтийн хамт)</td></tr>
<tr><td>4.4</td><td>Радио давтамжийн n79 зурвасын 4500-4800 МГц болон n258, n259/n260 зурвасыг дүүрэг, сум, хороо, багийн хамрах хүрээгээр бодлогын чиглэлийн дагуу хувийн болон дотоод хэрэглээнд ашиглаж болно.</td><td>Өөрчлөн найруулах</td></tr>
<tr><td>4.8</td><td>ДҮХХ-ны системд ашиглах РД-ийн зурвасын хуваарилалтыг гуравдугаар хүснэгтэд тодорхойлсон горим, хамрах хүрээгээр харилцаа холбооны үйлчилгээ (яриа, дата, мессеж) эрхлэгчид хуваарилж ашиглана.</td><td>Өөрчлөн найруулах</td></tr>
<tr><td>Хүснэгт 3</td><td><table>
<tr><th>№</th><th>Зурвасын дугаар</th><th colspan="2">Радио давтамжийн зурвас (МГц)</th><th>Горим</th><th>Хамрах хүрээ</th><th>Ашиглах сүлжээ</th></tr>
<tr><td>1</td><td>31</td><td>452.5 - 457.5</td><td>462.5 - 467.5</td><td rowspan="8">FDD</td><td rowspan="7">Монгол Улс</td><td>2G, ДҮХХ</td></tr>
<tr><td>2</td><td>28</td><td>713 - 748</td><td>768 - 803</td><td>ДҮХХ</td></tr>
<tr><td>3</td><td>5</td><td>824 - 844</td><td>869 - 889</td><td>2G, 3G ДҮХХ</td></tr>
<tr><td>4</td><td>20</td><td>847 - 862</td><td>806 - 821</td><td>ДҮХХ</td></tr>
<tr><td>5</td><td>8</td><td>880 - 915</td><td>925 - 960</td><td>2G, ДҮХХ</td></tr>
<tr><td>6</td><td>3</td><td>1710 - 1785</td><td>1805 – 1880</td><td>2G, ДҮХХ</td></tr>
<tr><td>7</td><td>1</td><td>1920 - 1980</td><td>2110 – 2170</td><td>3G, ДҮХХ</td></tr>
<tr><td>8</td><td>7</td><td>2500 - 2570</td><td>2620 - 2690</td><td rowspan="3">Улаанбаатар хот, аймаг, сум</td><td rowspan="5">ДҮХХ</td></tr>
<tr><td>9</td><td>40</td><td colspan="2">2300 - 2400</td><td rowspan="2">TDD</td></tr>
<tr><td>10</td><td>38</td><td colspan="2">2570 - 2620</td></tr>
<tr><td>11</td><td>n74</td><td>1427 - 1470</td><td>1475 - 1518</td><td>FDD</td><td>Монгол Улс</td></tr>
<tr><td>12</td><td>n78</td><td colspan="2">3300 - 3400</td><td>TDD</td><td></td></tr>
</table></td><td>Өөрчлөх</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td>
<table>
<tr><td>13</td><td>n77</td><td>3400 - 4200</td><td rowspan="5"></td><td rowspan="5">Улаанбаатар хот, аймаг, сум</td><td rowspan="5"></td></tr>
<tr><td>14</td><td>n79</td><td>4500 - 4800</td></tr>
<tr><td>15</td><td>n104</td><td>6425 - 7125</td></tr>
<tr><td>16</td><td>n258</td><td>24250 - 27500</td></tr>
<tr><td>17</td><td>n259/ n260</td><td>37000 - 43500</td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>3 дугаар хавсралт 3 дахь заалт</td>
<td>“...824-880 МГц-ийн...” гэснийг “...“...824-889 МГц-ийн...” гэж, “...824-834 / 869-879 МГц-ийн...” гэснийг “...824-844 / 869-889 МГц-ийн...” гэж тус тус</td>
<td>Өөрчлөх</td>
</tr>
<tr>
<td>9 дүгээр хавсралт</td>
<td>ДҮХХ n74, n77, n78, n79, n104 ДҮГЭЭР ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ</td>
<td>Өөрчлөн найруулах</td>
</tr>
<tr>
<td>9 дүгээр хавсралт хүснэгт</td>
<td>ҮРДХХ-д тодорхойлсон радио давтамжийн зурвасууд хүснэгтэд:
<table>
<tr>
<td>6425-7125 МГц</td>
<td>FIXED<br>FIXED-SATELLITE (Earth-to-space)<br>5.457A<br>5.457B<br>MOBILE<br>5.457C<br>5.457D<br>5.457E<br>5.457F<br><br>5.149 5.440<br>5.458</td>
<td>ХӨДӨЛГӨӨНТ БУС ХИЙМЭЛ ДАГУУЛЫН-ХӨДӨЛГӨӨНТ БУС (газар-сансар)<br><br>ХӨДӨЛГӨӨНТ<br>5.457E</td>
<td>6425-7125 МГц давтамжийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглана.</td>
<td>6425-7125 МГц давтамжийн зурвасыг дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд сонгон шалгаруулалтын журмаар олгоно.</td>
</tr>
</table>
</td>
<td>Хэсгийг нэмэх</td>
</tr>
<tr>
<td>9 дүгээр хавсралт 3 дахь заалт</td>
<td>Радио давтамжийн 3300-3400 МГц, 3400-4200 МГц, 4500-4800 МГц болон 6425-7125 МГц-ийн зурвасыг олон улсын стандартын 3GPP байгууллагаас тодорхойлсон TDD горимоор ашиглана.</td>
<td>Өөрчлөн найруулах</td>
</tr>
<tr>
<td>9 дүгээр хавсралт 4 дэх заалт</td>
<td>ДҮХХ-ны 3300-4200 МГц болон 6425-7125 МГц зурвас тус бүрээс нэг үйлчилгээ эрхлэгчид 150 МГц хүртэл, 4500-4800 МГц-ийн зурвасаас нэг үйлчилгээ эрхлэгчид 50 МГц хүртэл өргөнтэй зурвасыг хуваарилна.</td>
<td>Өөрчлөн найруулах</td>
</tr>
</table>

------o0o-----